



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/7/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь Сайншанд сум 2018 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
	Утас: 99092469	Цахим хаяг: .....
	Аудитын менежер:	Э.Энхцэцэг
	Утас: 90077079	Цахим хаяг: .....
	Аудитор:	Э.Батчимэг
	Утас: 99032916	Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дорноговь аймаг, Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3-р байр

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
	Анхан шатны маягтын заавар мөрдөж ажиллах .....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал .....	10



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/216

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
АЙРАГ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Н.ЛХАГВАДЭЛГЭР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.


**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Н.Лхагвадэлгэрд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.14-наас 2019.02.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Айраг сумын Цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.01.14-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг нь "СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж, бага насны хүүхдийн хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулна." гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл нь сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа юм.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцов.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг 2018 оны нийт зардал 313,078.95 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 626.16 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	80,894.50	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	80,894.50	

**2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

**2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Анхан шатны маягтын заавар мөрдөж ажиллах

**2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 303,822.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 302,307.8 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байна.

**2.11 Шилэн дансны мэдээлэл**

Айраг сумын Цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Айраг сумын хүүхдийн цэцэрлэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

- Нийт 16 ажилчдад ХЧТА-ын тэтгэмж олгохдоо ХХОАТ 159,5 мянган төгрөг суутгасан байна.
- 80,735.1 мянган төгрөгийн өараа материалыг няравын бараа материалын тайланд нэр төрлөөр болон нийт дүнгээр тайлагнаагүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Няравын бараа материалын тайланг нэр төрлөөр болон үнийн дүнгээр тайлагнаагүй , 80,735.1 мянган төгрөгийн бараа материалыг нийт дүнгээр тайлагнасан

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх, бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ хууль тус тус зөрчсөн байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Бараа материал биетээр оршин байхгүй байх, хөрөнгө шамшигдах

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн Сангийн сайдын 347 дугаар тогтоолоор баталсан Анхан шатны маягтын заавар мөрдөж ажиллах

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвшөөрсөн

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

16 ажилчдад ХЧТА-ын тэтгэмж олгохдоо 159,4 мянган төгрөгийн ХХОАТ суутгасан

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын хууль тус тус зөрчсөн байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу бүртгэсэн байх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Нийгмийн даатгалын хууль мөрдөж ажиллах

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвшөөрсөн

Түгэс

СТ-1А

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,890,837.36</b>	<b>80,735,139.45</b>
33	<b>АВЛАГА</b>	602,500.00	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	542,250.00	
335	<b>Бусад авлага</b>	60,250.00	
3351	Байгууллагаас авах авлага	60,250.00	
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	72,288,337.36	80,735,139.45
351	<b>Түүхий эд материал</b>	14,103,922.34	15,445,770.62
35110	Тусгай зориулалттай материал	14,089,712.34	15,435,570.62
35130	Эм боох материал	14,210.00	10,200.00
354	<b>Хангамжийн материал</b>	58,184,415.02	65,289,368.83
35410	Бичиг хэргийн материал	334,560.00	712,660.00
35420	Аж ахуйн материал	4,503,010.00	5,403,136.00
35450	Барилгын засварын материал	400,000.00	400,000.00
35460	Хүнсний материал	4,425,560.00	7,087,390.00
35470	Бусад хангамжийн материал	48,521,285.02	51,686,182.83
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>695,768,198.14</b>	<b>789,311,984.88</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	695,768,198.14	789,311,984.88
392	<b>Биет хөрөнгө</b>	695,731,531.58	784,825,984.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	725,407,900.00	745,103,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,168,846.98)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,627,680.00	42,111,480.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,542,283.45)	(30,436,368.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,248,518.00	40,761,318.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,014,849.89)	(24,445,823.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,191,406.00	11,068,663.18
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,116,992.10)	(1,436,132.70)
39217	Ном	2,099,000.00	2,099,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	36,666.56	4,486,000.00
39301	Програм хангамж	660,000.00	660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(623,333.44)	(660,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		4,486,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>768,659,035.50</b>	<b>870,047,124.33</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,265,250.00</b>	
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,265,250.00	
413	Өглөг	1,265,250.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>767,393,785.50</b>	<b>870,047,124.33</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	767,393,785.50	870,047,124.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	660,895,880.34	692,467,012.52
51101	Өмч: - төрийн	660,895,880.34	692,467,012.52
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	106,379,647.51	102,714,801.54
51210	Өмнөх үеийн үр дүн	106,379,647.51	106,379,647.51
51220	Тайлант үеийн үр дүн		(3,664,845.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	118,257.65	74,865,310.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>768,659,035.50</b>	<b>870,047,124.33</b>

4417144353  
E:QA0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	297,921,739.00	309,414,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,052,539.00	5,592,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,052,539.00	5,592,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,052,539.00	5,592,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,437,689.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,614,850.00	5,592,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,869,200.00	303,822,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	316,235,525.92	313,078,945.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,235,525.92	313,078,945.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,422,804.92	300,449,889.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,587,210.00	168,642,113.00
210101	Үндсэн цалин	134,866,508.00	145,843,303.00
210102	Нэмэгдэл	6,385,933.00	6,015,535.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,309,360.00	3,448,500.00
210104	Урамшуулал	10,025,409.00	13,334,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,975,842.00	20,050,177.00
210201	Тэтгэврийн даатгал	11,500,066.00	13,302,285.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,595,202.00	1,428,985.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,318,898.00	1,648,902.00
210204	Ажлалгүйдлийн даатгал	323,786.00	333,598.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,237,890.00	3,336,407.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,276,187.00	47,839,936.00
210301	Гэрэл, цахилгаан	4,783,006.00	5,300,109.00
210302	Түлш, халаалт	36,659,700.00	36,659,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,833,481.00	5,880,127.00
2104	Хангамж, бариа материалын зардал	1,764,137.00	5,106,721.91
210401	Бичиг хэрэг	654,740.00	487,700.00
210402	Тээвэр, шатахуун	562,490.00	564,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	441,907.00	538,648.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзгдэх, ахуйн эд зүйлс		2,930,843.91
2105	Нормативт зардал	49,842,907.41	37,879,604.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,720.00	45,210.00
210502	Хөөл, хунс	40,179,940.00	36,799,210.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,579,247.41	1,035,184.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	200,000.00	199,140.00
210604	Урсгал засвар	200,000.00	199,140.00
2107	Томиллолт, зочны зардал	112,000.00	212,200.00
210702	Дотоод албан томиллолт	112,000.00	212,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,360.00	292,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,360.00	292,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,599,161.51	20,227,998.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		457,000.00
210903	Үндсэн хөрөнгийн эзгдэл, хорогдол	22,599,161.51	19,770,998.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,812,721.00	12,629,056.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,564,500.00	11,114,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,211,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,228,300.00	11,114,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,125,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,248,221.00	1,514,256.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,248,221.00	1,514,256.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,313,786.92)	(3,664,845.97)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,044,078.42	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,044,078.42	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,044,078.42)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(19,357,865.34)	(3,664,845.97)

4417144353  
EIOA0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>290,306,889.00</b>	<b>303,822,100.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,437,689.00</b>	
120	Нийтэтг татварын бус орлого	1,437,689.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,437,689.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжэх	1,437,689.00	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>288,869,200.00</b>	<b>303,822,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжэх	288,869,200.00	303,822,100.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>286,693,089.00</b>	<b>298,758,300.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>286,693,089.00</b>	<b>298,758,300.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>266,880,368.00</b>	<b>286,129,244.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,120,702.00	168,642,113.00
210101	Үндсэн цалин	133,400,000.00	143,777,838.00
210102	Нэмэгдэл	6,385,933.00	8,081,000.00
210103	Унша хоолны хөнгөлөлт	5,309,360.00	3,448,500.00
210104	Урамшуулал	10,025,409.00	13,334,775.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгала төлөх шимтгэл	17,376,452.00	20,712,927.00
210201	Тэтгэврийн даатгал	11,141,676.00	13,999,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,534,952.00	1,540,600.00
210203	ҮОМШО-ний даатгал	1,270,698.00	1,521,550.00
210204	Ажилгүйдлийн даатгал	311,736.00	331,874.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,117,390.00	3,318,941.00
2103	Байр ашиглалттай хөлбөтөй тогтмол зардал	47,276,187.00	47,839,936.00
210301	Гэрэл, цахилгаан	4,783,006.00	5,300,109.00
210302	Түлш, халаалт	36,659,700.00	36,659,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,833,481.00	5,880,127.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,043,157.00	3,167,048.00
210401	Бичиг хэрэг	312,400.00	144,300.00
210402	Тээвэр, шатахуун	562,490.00	564,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	441,907.00	538,648.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	25,000.00
210405	Хөг хяягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	560,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,621,360.00	1,334,570.00
2105	Нормативт зардал	41,271,510.00	39,801,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,380.00	41,200.00
210502	Хоол, хүнс	40,886,130.00	39,461,120.00
210503	Нормын хувиас, зөөлөн эдлэл	320,000.00	299,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	3,982,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,782,400.00
210604	Урсгал засвар	200,000.00	200,000.00
2107	Томилголт, зочны зардал	112,000.00	90,200.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00	90,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,360.00	292,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтэтг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,360.00	292,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	415,000.00	1,600,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	415,000.00	1,600,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,812,721.00</b>	<b>12,629,056.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,564,500.00</b>	<b>11,114,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,211,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,228,300.00	11,114,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,125,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,248,221.00	1,514,256.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,248,221.00	1,514,256.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)-(1)-(2)</b>	<b>3,613,800.00</b>	<b>5,063,800.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,613,800.00</b>	<b>5,063,800.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,613,800.00</b>	<b>5,063,800.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	3,613,800.00	5,063,800.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮТ/	3,613,800.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,063,800.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)-(4)-(5)</b>	<b>(3,613,800.00)</b>	<b>(5,063,800.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)-(3)+(6)+(7)</b>		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсний үлдэгдэл		

4417144353  
EICA0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				*	
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн					
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	660,895,880.34	118,257.65	106,379,647.51		767,393,785.50
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	660,895,880.34	118,257.65	106,379,647.51		767,393,785.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		74,747,052.62			74,747,052.62
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн	31,571,132.18		(3,664,845.97)		27,906,286.21
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692,467,012.52	74,865,310.27	102,714,801.54		870,047,124.33


  
 4417144353  
 EICA0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ тогтогвоор /

Эмчийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>				
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	303,822,100.00	302,307,844.00	1,514,256.00	99.5%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	303,822,100.00	302,307,844.00	1,514,256.00	99.5%
2101	<b>Цалин хэлс болон нэмэгдэл урамшил</b>	292,707,300.00	291,193,044.00	1,514,256.00	99.5%
210101	Үндсэн цалин	169,483,900.00	168,642,113.00	841,787.00	99.5%
21010101	Үндсэн цалин	144,165,800.00	143,777,838.00	387,962.00	99.7%
21010102	Нэмэгдэл	8,081,000.00	8,081,000.00		100.0%
21010103	Уриа хоолны хөнгөлөлт	3,500,000.00	3,448,500.00	51,500.00	98.5%
21010104	Урамшуулал	13,737,100.00	13,334,775.00	402,325.00	97.1%
2102	<b>Ажил олгогчид нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,847,200.00	20,712,927.00	134,273.00	99.4%
210201	Тэтгэврийн даатгал	14,122,800.00	13,999,962.00	122,838.00	99.1%
210202	Тэтгэмжийн даатгал	1,366,800.00	1,540,600.00	(173,800.00)	112.7%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,659,200.00	1,521,550.00	137,650.00	91.7%
210204	Ажилгүйдлийн даатгал	336,200.00	331,874.00	4,326.00	98.7%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,362,200.00	3,318,941.00	43,259.00	98.7%
2103	<b>Байр ашиглалттай хялбоотой тогтмол зардал</b>	48,368,800.00	47,839,936.00	528,864.00	98.9%
210301	Гэрэл, ханхиван	5,368,100.00	5,300,109.00	67,991.00	98.7%
210302	Түлш, хавьлт	36,659,700.00	36,659,700.00		100.0%
210303	Цэвэр, бохир ус	6,341,000.00	5,880,127.00	460,873.00	92.7%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,174,600.00	3,167,048.00	7,552.00	99.8%
210401	Биеэв хэрэг	96,700.00	144,300.00	(47,600.00)	149.2%
210402	Тээвэр, шатахуун	562,500.00	564,530.00	(2,030.00)	100.4%
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	593,800.00	538,648.00	55,152.00	90.7%
210404	Ном, хэвлэл	25,000.00	25,000.00		100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	560,000.00	560,000.00		100.0%
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд зүйлс	1,336,600.00	1,334,570.00	2,030.00	99.8%
2105	<b>Нормативт зардал</b>	39,802,500.00	39,801,920.00	580.00	100.0%
210501	Эм, бодмол, эмнэлгийн хэрэгсэл	41,200.00	41,200.00		100.0%
210502	Хоол, хүнс	39,461,300.00	39,461,120.00	180.00	100.0%
210503	Нормын хувиас, зөөлөн эдлэл	300,000.00	299,600.00	400.00	99.9%
2106	<b>Эд хөгжим, урсгал засварын зардал</b>	9,047,100.00	9,046,200.00	900.00	100.0%
210601	Багш, техник хэрэгсэл	8,847,100.00	8,846,200.00	900.00	100.0%
210604	Урсгал засвар	200,000.00	200,000.00		100.0%
2107	<b>Томьлолт, зочны зардал</b>	90,200.00	90,200.00		100.0%
210702	Дотоод албан томьлолт	90,200.00	90,200.00		100.0%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажла, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	292,000.00	292,000.00		100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	292,000.00	292,000.00		100.0%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,601,000.00	1,600,700.00	300.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн далаага хийх	1,601,000.00	1,600,700.00	300.00	100.0%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,114,800.00	11,114,800.00		100.0%
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг				
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,114,800.00	11,114,800.00		100.0%
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	11,114,800.00	11,114,800.00		100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	303,822,100.00	303,822,100.00		100.0%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	303,822,100.00	303,822,100.00		100.0%
131007	Тусгай зориулалтын шилжүүлэх санхүүжих	303,822,100.00	303,822,100.00		100.0%
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих				
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>				
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>				
14	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>				
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	1,020.00	58,301.00	(57,281.00)	5715.8%
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00	(7,323.00)	1419.5%
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00	(4,090.00)	998.9%
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00	(45,868.00)	458780.0%
63	<b>СУРАЦАГЧИДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДААР)</b>				
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЦАГЧИД</b>				
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>				
632	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>				
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>				
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				

4417144353  
E:OA0056 9025707